

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудитын тайлан.....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал .....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	16
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	18
4.4 удит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	20
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	21
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	23
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	24

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

БАРИЛГЫН ПОЛИТЕХНИК  
КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ  
Г.НЯМДУЛАМ ТАНАА

2020.02.27 № 06/625  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Барилгын политехник коллежийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Барилгын политехник коллежийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Барилгын политехник коллежийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Барилгын политехник коллежийн захирлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Барилгын политехник коллежийн захирал Г.Нямдулам танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн дуусаагүй барилга болон маргаантай байгаа газрын асуудлыг шийдвэрлэх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг сайжруулах, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг цаг тухайд нь байршуулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Барилгын политехник коллежийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Барилгын политехник коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Ихмонгол хөлөг Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Барилгын политехник коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 9-ны өдрийн 03/52 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Барилгын политехник коллежийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Нийгмийн түншлэл, ажил олгогчдын оролцоог нэмэгдүүлж, хувь хүний чадамжинд суурилсан, мэдээллийн технологид тулгуурласан, ирээдүйг угтсан, насан туршийн боловсрол олгох сургалтын тогтолцоог бий болгож, сургалтын орчныг сайжруулан, багшлах боловсон хүчний чадавхийг дээшлүүлж, төлөвшсөн, чадварлаг мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд оршино.

Барилгын политехник коллежийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн хөгжлийн төлөвлөлт, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох
- Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх
- Багш, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх
- Багшлах боловсон хүчний чадавхийг үе шаттайгаар дээшлүүлэх
- Эрдэм шинжилгээ, судалгаа, туршилтын ажлыг гүйцэтгэх
- Санхүү, сургалтын орчинг сайжруулах гэсэн арга замыг хэрэгжүүлж ажиллана.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ;
- Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн хэмжээ;
- Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2019 оноос мөрдөж эхэлсэн;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж нээлттэй мэдээллэх;
- Засгийн газрын “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 2019 оны 276 тугаар тогтоолоор цалингийн зэрэглэл өөрчлөгдсөн.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Барилгын политехник коллежийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Барилгын политехник коллежийн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous-4.0” программ хангамж ашигладаг байна.

Барилгын политехник коллежийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Барилгын политехник коллежийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 15 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,666,237.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 26,662.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд 33,228.6 мянган төгрөгөөр материаллаг түвшин тогтоосон нь тайлант оны суурь үзүүлэлтийн дүнгээс тооцсонтой холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Барилгын политехник коллежийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө, нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 262,788.8 мянган төгрөгөөр буюу 6.03 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	20.2	20.7	0.4
Авлага	42,645.4	40,754.2	(1,891.3)
Урьдчилгаа	954.2	1,000.2	46.0
Бараа материал	335,926.8	342,370.9	(6,444.1)
Үндсэн хөрөнгө	3,969,434.9	3,702,646.2	(266,788.8)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,348,981.6</b>	<b>4,086,792.1</b>	<b>(262,788.8)</b>
Өр төлбөр	39,672.2	64,899.7	25,227.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,309,309.4	4,021,892.5	(287,417.0)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>4,348,981.6</b>	<b>4,086,792.1</b>	<b>(262,788.8)</b>

Авлагын оны эхний 42,645.4 мянган төгрөгийн үлдэгдлийг бүрэн барагдуулсан байна.

Үүнд: Сургалтын төлбөрийн 24,022.0 мянган төгрөг, татаас санхүүжилтийн 5,920.0 мянган төгрөг, ажилтан албан хаагчдаас авах 10,511.2 мянган төгрөг, бусад байгууллагаас авах 2,192.2 мянган төгрөгийн авлагуудыг барагдуулсан байна.

Тайлант хугацаанд шинээр бүртгэсэн 40,754.2 мянган төгрөгийн авлагын 52% буюу 21,253.0 мянган төгрөг нь оюутны сургалтын төлбөрийн, 27,6% буюу 11,256.0 мянган төгрөг нь дотуур байранд амьдардаг оюутны барьцаа төлбөрийг Сангийн яаманд төвлөрүүлснээс, дотуур байр түрээслэгчдээс хог, цахилгааны төлбөрийн 8.5% буюу 3,454.7 мянган төгрөг, мөн байгууллагаас авах авлагыг, урьдчилж төлсөн зардлаар бүртгэснийг авлагаар бүртгүүлж залруулснаас 7,2% буюу 2,902.0 мянган төгрөгийн авлага тус тус шинээр үүссэн байна.

Тайлант хугацаанд урьдчилгаа дансны оны эхний үлдэгдэл 954.2 мянган төгрөгийг ажилчдаас суутган барагдуулж, нийгмийн даатгалын байгууллагад 356.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, татварын байгууллагад 37.7 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 485.4 мянган төгрөгийн төвлөрүүлэх орлогыг тус тус илүү шилжүүлж, даатгалын төлбөрт 120.8 мянган төгрөгийг төлж, нийт 1,000.2 мянган төгрөгийн урьдчилж төлсөн тооцоо шинээр үүссэн байна.

Бараа материалын 342,370.9 мянган төгрөгийн оны эцсийн үлдэгдлийн 5.1% буюу 17,478.6 мянган төгрөгийг бичиг хэрэгслийн материал, 10.5% буюу 36,110.6 мянган



төгрөгийн аж ахуйн эд хогшил, 15 % буюу 51,421.8 мянган төгрөг хичээл үйлдвэрлэлийн зориулалттай материал, 60.6 % буюу 207,618.0 мянган төгрөгийн хичээл дадлагын материал тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс 47,472.1 мянган төгрөгийн, Мэргэжлийн сургалт түншлэл ГҮТББ-ээс 19,039.7 мянган төгрөгийн, хувь хүн бусад байгууллагаас 12,345.1 мянган төгрөгийн, Монполимер хоолой ХХК-аас 2,999.5 мянган төгрөгийн нийт 81,856.4 мянган төгрөгийн бараа материалыг хандиваар, төсвийн хөрөнгөөр 243,196.0 мянган төгрөгийн бараа материалыг бэлтгэсэн байна.

Дуусаагүй үйлдвэрлэлд бүртгэсэн, камер суурилуулахтай холбоотой 38,821.5 мянган төгрөгийн зардлын дүнгээр үндсэн хөрөнгийг капиталжуулсан.

Төсөвт байгууллагын барилга, байгууламж, газар эзэмших эрхийг 2018 онд дахин үнэлж, цэвэр дүнгээр санхүүгийн тайланд тайлагнасан.

Тайлант хугацаанд “Саммит Компьютер Технологи” ХХК-аас 143,823.7 мянган төгрөгийн компьютер дагалдах хэрэгсэл, “Германы хамтын ажиллагаа нийгэмлэг”-ээс 9,470.0 мянган төгрөгийн сургалтын багаж хэрэгсэл, “Мэргэжлийн боловсрол сургалт түншлэл” ГҮТББ-аас 14,986.5 мянган төгрөгийн сургалтын материал, тавилга эд хогшил, “Вюрт Монголиа” ХХК-аас 40,050.0 төгрөгийн сургалтын багаж хэрэгсэл, “Топ нет” ХХК-аас 6,086.8 мянган төгрөгийн интернет сүлжээ, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас 350.0 мянган төгрөгийн ном, бусад байгууллагаас 254.4 мянган төгрөгийн сургалтын материал, нийт 215,021.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хандиваар авсан байна.

Нийт өр төлбөрийн дүн оны эхнээс 25,227.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь урьдчилж орсон сургалтын төлбөр, оюутны барьцаа, түрээсийн орлого 33,1969.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 5 хөтөлбөрийн хүрээнд 2,702,530.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 194,710.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Улсын төсвөөс 2,702,530.9 мянган төгрөгийн санхүүжилт бүрэн олгогдсон байна.

Барилгын политехник коллежийн үндсэн үйл ажиллагааны орлого 46,279,0 мянган төгрөгөөр тасарсан нь 2016 оноос хойш “Техникийн боловсрол олгох” бакалаврын элсэлт авахыг зогсоосон ч үйл ажиллагааны орлогыг төсөвлөхдөө бууруулахгүйгээр баталснаас шалтгаалжээ.

Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 48,618.8 мянган төгрөгөөр давсан нь оюутны дотуур байр түрээслэгчдийн гэрээний үүрэг хариуцлага, хяналтыг сайжруулж, хог, цахилгааны төлбөрийг нөхөн авахаар орлогоор бүртгэсэнээс шалтгаалсан байна.

Төсвийн зардлын гүйцэтгэл 2,896,432.4 мянган төгрөг буюу зарцуулаагүй үлдэгдэл 808.5 мянган төгрөг болон давсан орлого 2,339.8 мянган төгрөг нийт 3,147.8 мянган төгрөг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Гэрэл цахилгааны зардал 1.8 мянган төгрөгөөр, цэвэр бохир усны зардал 1.2 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардал 0.8 мянган төгрөгөөр бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал 1.3 мянган төгрөгөөр, урсгал засварын зардал 0.8 мянган төгрөгөөр тус



тус хэтэрсэн боловч зардлын бүлгийн дүнгээр нийт 0.8 мянган төгрөгийн зардлын хэмнэлттэй ажилласан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд улсын төсвөөс 400.0 мянган төгрөг, хандив тусламжийн орлогоор 4,071.4 мянган төгрөгийг бүрдүүлж, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 3,915.4 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 556.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 15 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 7 эрсдэл тодорхойлж нийт 22 горим сорил хэрэгжүүлээ.

Аудитаар нийт 639,263.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 618,164.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,904.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 9,723.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 8,471.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Суралцагчдын тоог үндэслэлгүй нэмж, өдрийн хоолны батлагдсан нормыг тогтоосон хэмжээнээс илүү тооцож 2,904.0 төгрөгийг харилцагч байгууллагад шилжүүлснийг, урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1.4 -д " Үнэн зөв байх", толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд авлагаар бүртгэж залруулсан.

2. 2018 онд хийгдсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр биет бус хөрөнгөөр бүртгэсэн 390,964.3 мянган төгрөгийн газар эзэмших эрхийн ашиглах хугацааг санхүүгийн програмд 1 жилээр бүртгэн 367,999.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Биет бус хөрөнгийн дансанд залруулж бүртгэсэн.

3. Оюутны дотуур байрны "түрээсийн гэрээний 2.4-т сар бүр цахилгааны төлбөр 153.0 мянган төгрөг, хогны төлбөр 5.0 мянган төгрөгийн төлбөр төлнө" гэж заасан боловч нийт 2,591.0 мянган төгрөгийн цахилгааны төлбөр, 863.7 мянган төгрөгийн хаягдлын нийт 3,454.7 мянган төгрөгийг барагдуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд авлагаар бүртгэж залруулсан.

4. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүүг шалгахад 2018 оны жилийн эцсийн хөрөнгийн дахин үнэлгээний бичилтийг Acolous программд алдаатай татсанаас 243,806,9 мянган төгрөгөөр дахин үнэлгээний нэмэгдлийг илүү дүнгээр тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулж тайлагнасан.

5. Дадлагын 150 оюутныг дотуур байранд байрлуулж, дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас 9,723.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалын 6 дугаар хавсралтад Хоолны зардал (тухайлбал... сургалт үйлдвэрлэлийн төвүүд болон ерөнхий боловсролын сургуулиудын хүүхдийн дотуур байрны хоолны зардал), Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх" ...сургуулиудын хичээлийн байрандаа буюу хичээлийн байрнаас гадагш явж дадлага хийхтэй холбогдсон зардал" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

6. Оюутны дотуур байранд амьдрах суралцагчдын бүртгэлийг, байрны багшийн өдөр тутмын бүртгэлтэй тулган шалгахад дараахь зөрчлүүд илэрлээ. Үүнд: 2019 оны 12 дугаар сарын ирцийн бүртгэлд 121 суралцагчийг 8 хоногоор давхардуулан бүртгэж, нэг суралцагчийн хоногийн хоолны батлагдсан нормыг зөрчин 2,904.0 мянган төгрөгийн хоолны зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д " Үнэн зөв байх" , 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын 3-т "мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоолны зардлыг 2315 (Хоёр мянга гурван зуун арван таван) төгрөгөөр тогтоосугай", гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, эрх ба үүрэг, оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн 8,471.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Газрын маргаантай асуудлын шийдвэрлэлт, хэрэгжихээр батлагдсан төсөл хөтөлбөрүүдтэй холбогдуулан хандивын хөрөнгийн бүртгэл тайлагналыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **2.13. Шилэн дансны мэдээлэл**

Барилгын политехник коллеж нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 18 мэдээллийг хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 71,907.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Нийт 5 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

## **2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Барилгын политехник коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 21,098.5 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 33,228.6 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Барилгын политехник коллежийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

3.1.1 Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох стандарт, хууль, журам, зааврын шинэчлэлийг тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 18.2-т “ Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлог, стандарт, хууль, тушаал, зааварт нийцэхгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт стандарт, хууль, тушаал, зааварт холбогдох өөрчлөлтүүдийг тусган шинэчилж мөрдөх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### 3.2 Дуусаагүй барилга

3.2.1 Илрүүлэлт: Он удаан жил бүртгэгдэж ирсэн дуусаагүй барилга, байгууламжид биет тест гүйцэтгэхэд Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт 2 га талбай бүхий эзэмших эрхийн гэрчилгээтэй, амралтын зориулалттай, барьж дуусаагүй тоосгон хашаа, 4 амралтын байр эвдэрч тоногдсон цаашид сэргээн босгоход ихээхэн хөрөнгийн эх үүсвэр шаардагдахаар байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 14.1-т” Өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн, зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах” гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хууль, тогтоомжийг мөрдөхгүй байх.

- 3.2.3 Өгсөн зөвлөмж: Уг дуусаагүй хөрөнгийг Өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн цаашид авах арга хэмжээг холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх
- 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **3.3 Анхан шатны баримттай холбоотой**

- 3.3.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд худалдан авалт хийхдээ зарлагын баримттай боловч төлбөрийн баримт /и баримт/-ыг хавсаргаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм.” гэж заасан, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.
- 3.3.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хууль, тогтоомжийг мөрдөхгүй байх.
- 3.3.3 Өгсөн зөвлөмж: Худалдан авалт хийхдээ төлбөрийн баримт /и баримт/-ыг авч хэвших
- 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **3.4 Биет бус хөрөнгийн талаар**

- 3.4.1 Илрүүлэлт: Байгууллагаас зарга маргааны талаар асуулга авахад, сургалтын зориулалтай, биет бус хөрөнгөнд бүртгэлтэй Мужааны цех (Газар-3)-ийн газарт 74 айлын ажилчдын орон сууцны барилга барьж 2017 онд ашиглалтад оруулсан байна. Одоо уг газрыг хичээл сургалт үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах боломжгүй, нийтийн эзэмшилд байна.
- 3.4.2 Эрсдэл: Биетээр байхгүй хөрөнгийг бүртгэж тайлагнасан байх
- 3.4.3 Өгсөн зөвлөмж: Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдахгүй, зориулалт нь өөрчлөгдсөн 800 м2 газрыг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.
- 3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **3.5 Зардлын талаар**

- 3.5.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд 8,471.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг цалин хөлсний зардалд шилжүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан зарлагын эдийн засгийн ангилал” гэж заасантай нийцэхгүй байна.
- 3.5.2 Эрсдэл: Батлагдсан зардлын ангиллыг мөрдөөгүй байх
- 3.5.3 Өгсөн зөвлөмж: Батлагдсан зардлын ангиллыг мөрдөж ажиллах

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **3.6 Дотоод хяналтын талаар**

3.6.1 Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 18 мэдээллийг хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.6.2 Эрсдэл: Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх

3.6.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансанд тавих дотоод хяналтыг сайжруулах, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	379,546,698.82	384,145,957.85
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	20,200.00	20,645.50
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	20,200.00	20,645.50
31110	Төгрөг	20,200.00	20,645.50
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
3121	Төгрөг	0.00	0.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	0.00
33	АВЛАГА	42,645,438.00	40,754,179.41
33300	Татаас санхүүжилтийн авлага	5,920,000.00	11,256,000.00
335	Бусад авлага	36,725,438.00	29,498,179.41
3351	Байгууллагаас авах авлага	2,192,260.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	34,533,178.00	29,498,179.41
34	УРЬДЧИЛГАА	954,222.00	1,000,221.25
34600	Урьдчилж гарсан зардал	3,000.00	1,000,221.25
3471	Урьдчилгаа тооцоо	951,222.00	0.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0.00	0.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	(0.00)
34713	Цалингийн урьдчилгаа	951,222.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	335,926,838.82	342,370,911.69
351	Түүхий эд материал	53,312,023.04	52,789,958.17
35110	Тусгай зориулалттай материал	51,769,324.32	51,421,785.17
35130	Эм боох материал	1,542,698.72	1,368,173.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	18,842,522.24	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	7,311,575.00	5,401,575.00
354	Хангамжийн материал	256,460,718.54	284,179,378.52
35410	Бичиг хэргийн материал	16,463,699.41	17,478,065.71
35420	Аж ахуйн материал	10,999,100.00	11,707,597.98
35430	Сэлбэг хэрэгсэл	4,523,600.00	4,171,000.00
35440	Түлш шатах тослох материал	200,000.00	424,000.00
35450	Барилгын засварын материал	6,679,100.00	6,670,100.00
35470	Бусад хангамжийн материал	216,895,219.13	243,728,614.83
35460	Хоол, хүнс	700,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,969,434,940.04	3,702,646,157.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,969,434,940.04	3,702,646,157.39
392	Биет хөрөнгө	3,566,513,684.52	3,306,556,109.87
39201	Барилга, байгууламж	7,059,643,870.08	7,059,643,870.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	(4,587,870,494.10)	(4,893,216,795.36)
39203	Авто тээврийн хэрэгсэл	232,686,000.00	232,686,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(130,399,198.07)	(159,727,626.59)
39205	Машин, тоног төхөөрөмж	2,660,699,654.58	2,921,256,900.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,053,293,505.56)	(2,263,871,535.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	288,383,304.08	333,427,339.08
39208	Хуримтлагдсан элэгдэл	(191,202,484.26)	(214,786,107.79)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	13,522,650.00	13,522,650.00
39217	Номын фонд	274,343,887.77	277,621,414.77
393	Биет бус хөрөнгө	402,921,255.52	396,090,047.52
39301	Програм хангамж	64,041,234.87	64,041,234.87
39302	Хасагдуулга	(52,084,319.35)	(58,915,527.35)
39303	Бусад биет бус хөрөнгө	390,964,340.00	390,964,340.00

Барилгын политехник коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,348,981,638.86	4,086,792,115.24
